

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨВА-2026/149/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өвөрхангай аймаг,  
Арвайхээр сум

2026 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323833 Цахим хаяг: Khorloosuren.p.audit@gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: erdenetsetsegb@audit.gov.mn

Чадварлаг Аудит ХХК-ийн захирал: Д.Рэнцэнханд

Утас: 99200034 Цахим хаяг: chadvarlagAudit@gmail.com

Аудитор: П.Сосорбурам

Утас: 94422277 Цахим хаяг: sosorburampurev3@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025-02-05 № 33  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НАРИЙНТЭЭЛ СУМЫН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ц.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Бидний дүгнэлтээр Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Цэцэрлэгийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд хандив тусламжаар авсан 24.0 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

2025 онд 8 хөтөлбөр арга хэмжээнд 857.6 сая төгрөгийг зарцуулж зардлын гүйцэтгэл 97.1 хувьтай байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд улсын төсвөөс 742.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 46.6 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 5.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. 2025 онд 32.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

#### Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллага нь 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт төсөл, 42 арга хэмжээ төлөвлөж 72.0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

6225020102

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>161,856,522.72</b>	<b>83,676,845.08</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	100,675,894.95	32,101,988.96
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	100,675,894.95	32,101,988.96
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	100,675,894.95	32,101,988.96
31211	Төрийн сангийн харилцах	100,675,894.95	32,101,988.96
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,386,958.77	1,715,409.12
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,491,358.77	1,715,409.12
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	895,600.00	-
33510	Байгууллагаас авах авлага	895,600.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	58,793,669.00	49,859,447.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,575,300.00	4,575,300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	54,218,369.00	45,284,147.00
35420	Аж ахуйн материал	41,922,677.00	35,808,345.00
35460	Хүнсний материал	12,295,692.00	9,420,802.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,241,864,633.38</b>	<b>1,222,633,343.23</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,241,864,633.38	1,222,633,343.23
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,233,789,633.38	1,214,738,343.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,302,632,818.46	1,302,632,818.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(120,832,136.67)	(164,632,461.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,271,770.85	56,931,770.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,019,365.61)	(39,741,481.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,624,426.50	40,344,426.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,224,924.78)	(13,375,723.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,464,400.00	34,921,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,306,526.37)	(4,521,276.95)
39217	Ном	2,179,171.00	2,179,171.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,075,000.00	7,895,000.00
39301	Програм хангамж	1,915,000.00	1,915,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,360,000.00)	(1,540,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,520,000.00	7,520,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,403,721,156.10</b>	<b>1,306,310,188.31</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>418,454.12</b>	<b>1,206,445.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	418,454.12	1,206,445.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	418,454.12	1,206,445.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	418,454.12	16,445.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,403,302,701.98</b>	<b>1,305,103,743.31</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,403,302,701.98	1,305,103,743.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	74,829,726.00	74,829,726.00
51101	Өмч: - төрийн	74,829,726.00	74,829,726.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,102,356,099.97	1,004,157,141.30
51210	Өмнөх үеийн үр дүн	1,064,905,538.38	1,102,356,099.97
51220	Тайлант үеийн үр дүн	37,450,561.59	(98,198,958.67)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	226,116,876.01	226,116,876.01
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,403,721,156.10</b>	<b>1,306,310,188.31</b>

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Цэцэрлэгийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>799,830,650.00</b>	<b>832,208,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>31,288,750.00</b>	<b>43,203,700.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	31,288,750.00	43,203,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	545,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	545,000.00	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	30,743,750.00	38,336,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>768,541,900.00</b>	<b>789,004,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	718,004,800.00	742,398,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	718,004,800.00	742,398,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	50,537,100.00	46,606,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,537,100.00	46,606,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>762,380,088.41</b>	<b>930,407,258.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>762,380,088.41</b>	<b>930,407,258.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	755,384,064.41	924,893,093.67
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	513,612,920.50	637,783,639.97
210101	Үндсэн цалин	346,793,557.47	412,151,899.47
210102	Нэмэгдэл	144,410,743.23	187,949,096.02
210104	Урамшуулал	22,408,619.80	18,621,362.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	65,743,396.84	75,698,206.55
210201	Тэтгэврийн даатгал	45,008,359.23	51,410,206.65
210202	Тэтгэмжийн даатгал	5,059,255.92	6,058,399.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,516,583.22	3,040,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,713,083.22	3,040,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,446,115.25	12,148,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,096,076.00	47,907,835.00
210301	Гэрэл, цахилгаан	6,334,500.00	8,844,850.00
210302	Түлш, халаалт	40,761,576.00	39,062,985.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	55,169,290.00	62,599,940.00
210502	Хоол, хүнс	55,169,290.00	62,599,940.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,421,500.00	2,342,000.00
210604	Урсгал засвар	2,421,500.00	2,342,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,107,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	71,340,881.07	77,649,240.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,865,240.00	15,518,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,317,800.00	4,063,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,157,841.07	58,067,990.15
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,996,024.00	5,514,165.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,552,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,552,500.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,443,524.00	5,514,165.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,443,524.00	5,514,165.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>37,450,561.59</b>	<b>(98,198,958.67)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>37,450,561.59</b>	<b>(98,198,958.67)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>769,086,900.00</b>	<b>789,039,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>545,000.00</b>	<b>35,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	545,000.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	545,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	545,000.00	35,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>768,541,900.00</b>	<b>789,004,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	718,004,800.00	742,398,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	718,004,800.00	742,398,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	50,537,100.00	46,606,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,537,100.00	46,606,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>720,659,281.84</b>	<b>857,613,505.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>720,659,281.84</b>	<b>857,613,505.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>713,663,257.84</b>	<b>852,099,340.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>514,226,218.35</b>	<b>638,326,406.09</b>
210101	Үндсэн цалин	347,406,855.32	412,694,665.59
210102	Нэмэгдэл	144,410,743.23	187,949,096.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,061,282.00
210104	Урамшуулал	22,408,619.80	18,621,362.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>65,660,103.49</b>	<b>75,781,499.90</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,925,065.88	51,493,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,059,255.92	6,058,399.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,516,583.22	3,040,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,713,083.22	3,040,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,446,115.25	12,148,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>47,096,076.00</b>	<b>47,907,835.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,334,500.00	8,844,850.00
210302	Түлш, халаалт	40,761,576.00	39,062,985.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>61,686,320.00</b>	<b>58,535,050.00</b>
210502	Хоол, хүнс	61,686,320.00	58,535,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,997,500.00</b>	<b>5,895,000.00</b>
210604	Урсгал засвар	1,997,500.00	5,895,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>3,107,100.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,107,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,997,040.00</b>	<b>22,546,450.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,448,240.00	17,230,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,548,800.00	5,316,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,996,024.00</b>	<b>5,514,165.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,552,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,552,500.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,443,524.00	5,514,165.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,443,524.00	5,514,165.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>48,427,618.16</b>	<b>(68,573,905.99)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,734,000.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,734,000.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	3,734,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,734,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(3,734,000.00)</b>	-
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	44,693,618.16	(68,573,905.99)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	55,982,276.79	100,675,894.95
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	100,675,894.95	32,101,988.96

## 2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	74,829,726.00	226,116,876.01	1,064,905,538.38	1,365,852,140.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	74,829,726.00	226,116,876.01	1,064,905,538.38	1,365,852,140.39
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	37,450,561.59	37,450,561.59
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,829,726.00	226,116,876.01	1,102,356,099.97	1,403,302,701.98
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	74,829,726.00	226,116,876.01	1,102,356,099.97	1,403,302,701.98
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	74,829,726.00	226,116,876.01	1,102,356,099.97	1,403,302,701.98
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(98,198,958.67)	(98,198,958.67)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,829,726.00	226,116,876.01	1,004,157,141.30	1,305,103,743.31

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>882,804,000.00</b>	<b>857,613,505.99</b>	<b>25,190,494.01</b>	<b>97.15</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>882,804,000.00</b>	<b>857,613,505.99</b>	<b>25,190,494.01</b>	<b>97.15</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>882,804,000.00</b>	<b>852,099,340.99</b>	<b>30,704,659.01</b>	<b>96.52</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	655,798,500.00	638,326,406.09	17,472,093.91	97.34
210101	Үндсэн цалин	417,173,600.00	412,455,101.05	4,718,498.95	98.87
210102	Нэмэгдэл	224,441,200.00	188,188,660.56	36,252,539.44	83.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,061,282.00	(19,061,282.00)	
210104	Урамшуулал	14,183,700.00	18,621,362.48	(4,437,662.48)	131.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,540,700.00	75,781,499.90	5,759,200.10	92.94
210201	Тэтгэврийн даатгал	55,308,800.00	51,493,500.00	3,815,300.00	93.10
210202	Тэтгэмжийн даатгал	6,557,900.00	6,058,399.90	499,500.10	92.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,279,000.00	3,040,800.00	238,200.00	92.74
210204	Ажилгүйдлийн даатгал	3,279,000.00	3,040,800.00	238,200.00	92.74
210205	Эрүүл мэндийн даатгал	13,116,000.00	12,148,000.00	968,000.00	92.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,422,000.00	47,907,835.00	5,514,165.00	89.68
210301	Гэрэл, цахилгаан	10,260,000.00	8,844,850.00	1,415,150.00	86.21
210302	Тулш, халаалт	40,762,000.00	39,062,985.00	1,699,015.00	95.83
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	-	2,400,000.00	-
2105	Нормативт зардал	60,024,500.00	58,535,050.00	1,489,450.00	97.52
210502	Хоол, хүнс	60,024,500.00	58,535,050.00	1,489,450.00	97.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,895,000.00	5,895,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,895,000.00	5,895,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хура	3,107,100.00	3,107,100.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,107,100.00	3,107,100.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,016,200.00	22,546,450.00	469,750.00	97.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,699,800.00	17,230,050.00	469,750.00	97.35
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,316,400.00	5,316,400.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,514,165.00	(5,514,165.00)	
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,514,165.00	(5,514,165.00)	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,514,165.00	(5,514,165.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	100,675,894.95	(100,675,894.95)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	32,101,988.96	(32,101,988.96)	

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3 зөрчил<sup>1</sup> илэрч 3 албан шаардлага өгсөн.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй.

### 3.2 Албан шаардлага

#### 1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн Б/26 тоот тушаалаар нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,559,000 төгрөгийн балансын урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.2-д "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, албан шаардлагаар тогтоосон зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2026 оны 5 дугаар сарын 15-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

#### 2.Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангаар Нийгмийн даатгалын шимтгэлд 1,715.4 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, албан шаардлагаар тогтоосон зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2026 оны 5 дугаар сарын 15-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

#### 3.Илрүүлэлт:

Албан томилолтоор ажилласан хугацаанд 8 албан хаагчид 95.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг томилолтын хоолны зардалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.3-д "Гүйцэтгэж байгаа албан 1 Хүчин

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Цэцэрлэгийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл, үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.2-д "албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ", 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-д "байрны зардал", 2.2.3-д "хоолны зардал", 8.4-д "Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

### 3.3 Зөвлөмж

Зөвлөмж бичигдээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн Б/26 тоот тушаалаар нягтлан бодогчид 1сарын үндсэн цалинтай тэнцэх 1559000 төгрөгийн балансын урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон	1	1,559.0			1	1,559.0						
Санхүүгийн тайлангаар Нийгмийн даатгалын шимтгэлд 1,715.4 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна	1	1,715.4			1	1,715.4						
Албан томилолтоор ажилласан хугацаанд 8 албан хаагчид 95.0 мянган төгрөгийн хоолны	1	95.0			1	95.0						

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Цэцэрлэгийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

мөнгийг томилолтын хоолны зардалтай давхардуулан олгосон байна.										
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,369.4</b>			<b>3</b>	<b>3,369.4</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2026 оны 02 дугаар сарын 23



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 62/2025.222/100 2026/149/100-СТА-ТШЗ Арвайхээр сум

ЗӨРЧЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Нарийнтээл сумын Цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан"-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангаар Нийгмийн даатгалын шимтгэлд 1,715.4 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлж, авлага үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 15-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотоор, нотлох баримтын хамт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг ажиллахыг Нарийнтээл сумын Цэцэрлэгийн эрхлэгч (Ц.Энхцэцэг), Нягтлан бодогч (Ж.Шижирбаатар) нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ  
АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
"ЧАДВАРЛАГ" АУДИТ  
ХХК-ИЙН АУДИТОР П.СОСОРБУРАМ

Монгол улс, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг, Нутгийн удирдлагын ордон 4 давхар, Утас: 70323253

622504043Я



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 103/19625-2025/100-2026/149/10-07-ТШЗ Арвайхээр сум

ЗӨРЧЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Нарийнтээл сумын Цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан"-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн Б/26 дугаар тушаалаар нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1,559.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.2-д "Төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Балансын урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 15-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотоор, нотлох баримтын хамт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нарийнтээл сумын Цэцэрлэгийн эрхлэгч (Ц.Энхцэцэг), Нягтлан бодогч (Ж.Шижирбаатар) нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ  
АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
"ЧАДВАРЛАГ" АУДИТ  
ХХК-ИЙН АУДИТОР П.СОСОРБУРАМ

Монгол улс, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг, Нутгийн удирдлагын ордон 4 давхар, Утас:  
70323253

6225040492



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 104/19125223/1000-2026/149/НА-СТА-ТШЗ Арвайхээр сум

ЗӨРЧЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Нарийнтээл сумын Цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан"-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор ажилласан хугацаанд 8 албан хаагчид нийт 95.0 мянган төгрөгийн хоолны мөнгө олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1-д "Албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах", Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-д "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ", 2.2.3-д "Хоолны зардал", 8 дугаар зүйлийн 8.4-д "Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Унаа, хоолны зардлыг олгохдоо томилолтоор ажилласан хугацааны хоногийг хасаж тооцоогүй олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 15-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотой, нотлох баримтын хамт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нарийнтээл сумын Цэцэрлэгийн эрхлэгч (Ц.Энхцэцэг), Нягтлан бодогч (Ж.Шижирбаатар) нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ  
АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
"ЧАДВАРЛАГ" АУДИТ  
ХХК-ИЙН АУДИТОР П.СОСОРБУРАМ

6225040495

Монгол улс, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг, Нутгийн удирдлагын ордон 4 давхар, Утас: 70323253